



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 03 өдөр

Дугаар A/375

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шинээр гаргасан болон сэргээн засварласан инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны Бэлчээр, тэжээл усан хангамж хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгал орчин аялал жуулчлалын газрын Усны нөөцийн ашиглалт хамгаалалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

-Онги-Тааз голын сав газрын захиаргааны газрын доорх усны нөөц, хяналт, шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

-Сумдын ажлын хэсэг (Сумын Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн усан хангамж хариуцсан мэргэжилтэн)

2. Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргасан болон сэргээн засварласан инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг нэг бүрчлэн газар дээр нь үзэж, стандартын дагуу ашиглалтанд хүлээж авах ажлыг зохион багуулахыг ажлын хэсгийн ахлагч (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

20210803